

Санхүү, санхүүгийн системийн тухай шинжлэх ухааны үндсэн ойлголт

Science Principles on Finance and Financial Systems

Д. Намжил¹, П. Баянсан²

Хураангуй

Төр олон мянган жилийн туршид оршин тогтнож ирсэн эдийн засгийн үндэс нь татвар мөн. Татварын хөгжлийн явцад төлбөр, хураамж, элэгдэл хорогдлын шимтгэл, зээл гэх мэт олон хэрэгслүүд бий болсон. Санхүүгийн системийг бүрдүүлэхдээ эдгээр арга хэрэгслүүдийг ашиглана. Монгол Улсын санхүүгийн систем нь улсын санхүү, бизнесийн байгууллагын санхүү, өрхийн санхүү гэсэн бүрэлдэхүүн хэсэгтэй. Бүрэлдэхүүн хэсгүүдийн уялдаа, хөгжлийг хангах нь өнөөгийн Төрийн санхүүгийн тулгамдсан зорилт болж байна.

Түлхүүр үгс: санхүү, татвар, элэгдэл хорогдлын шимтгэл, хүү, зээл, хадгаламж

Abstract

Economic reason of existence of taxation for thousands of years is the Public. During the development of the taxation, the instruments such as payments, fees, depreciation, loans etc. were created. These instruments are used for the constitution of financial system. Mongolian financial system composes of public finance, corporate or business finance and household or personal finance. Ensuring the coherence and development of these components is the current major financial issue of the public.

Keywords: finance, tax, depreciation, interest rate, loan, saving

¹ МУИС-ийн Бизнесийн Сургуулийн Санхүүгийн тэнхимийн дэд профессор, доктор
E-mail: namjil_9777@yahoo.com

² МУИС-ийн Бизнесийн Сургуулийн Санхүүгийн тэнхимийн багш, докторант
E-mail: bayansan.p@num.edu.mn

Төр олон мянган жил оршин тогтнох эдийн засгийн үндэс нь шинээр бий болсон өртгийг хуваарилах зайлшгүй зүй тогтнолтой уялдаатайгаар санхүү, түүний харилцаа үүсч бий болсон юм. Нийгмийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хуваарилалтын шатанд тухайлбал нөхөн үйлдвэрлэлийн процесст шинэ өртөг буюу цалин, ашиг (орлого), рент хэлбэрээр анхдагч орлого бүрдэнэ. Эдгээр анхдагч орлого буюу шинээр бий болсон өртгийн тодорхой хэсгийг санхүүгийн харилцааны гол цөм болсон татварын тусламжтай анхны хуваарилалтаар улсын мэдлийн орлого (улсын төсөв) бүрдүүлнэ.

Татвар бол санхүүгийн шинжлэх ухааны үндсэн элемент бөгөөд нийгмийн бүтээгдэхүүний тодорхой хэсгийг улсын мэдэлд дайчлах хэрэгсэл юм³. Татвар нь өөрийн төрөлх шинж чанараар хүний санаа зорилгоос хамаарахгүйгээр хууль эрх зүйн хүрээнд шинэ өртөг буюу анхдагч орлогын тодорхой хэсгийг төвлөрсөн санд төвлөрүүлж төрийн мэдлийн орлого бүрдүүлэх санхүүгийн хэрэгсэл болдог. Татварын адил шинж чанартай төвлөрсөн сангийн орлого бүрдүүлэхэд идэвхтэй оролцож буй төлбөр, хураамж, шимтгэл зэрэг бусад санхүүгийн хэрэгсэл бүр нь өөрийн онцлог шинж чанартай боловч хууль эрх зүйн хүрээнд зайлшгүй баталгаажсан байдаг.

Төрөөс татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн арга хэрэгслийн (санхүүгийн) тусламжтайгаар санхүүгийн бодлогын хэрэгжилтийн хүрээнд төвлөрсөн санд орох санхүүгийн нөөцийг бүрдүүлдэг⁴. Төрийн төвлөрсөн санг бүрдүүлэхэд чухал үүрэгтэй оролцдог санхүүгийн арга

хэрэгсэл бол элэгдэл хорогдлын шимтгэл мөн. Элэгдэл хорогдлын шимтгэл нь нөхөн үйлдвэрлэлийн процесст идэвхтэй оролцдог үндсэн капиталын шинэчлэл, шинэ капитал бий болгох хөрөнгө оруулалтын нэг томоохон эх үүсвэр болно⁵.

Шинээр бий болсон нийгмийн бүтээгдэхүүнийг (өртгийг) санхүүгийн арга хэрэгсэл болох татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тусламжтайгаар хуваарилж Улсын болон бие даасан субъектүүдийн санхүүгийн нөөц бүрдүүлэлтийг ерөнхий бүдүүвч схемээр харууллаа (Зураг 1).

Нийгмийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн үр дүнд санхүү нь өөрийн үндсэн үүрэг болох хуваарилалтын үүргийн тусламжтайгаар:

- Татвар
- Төлбөр
- Хураамж
- Шимтгэл
- Ноогдол ашиг

зэрэг бусад санхүүгийн арга хэрэгслүүдээр улсын санхүүгийн болон төсвийн нөөц бий болгохоос гадна аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийн санхүүгийн нөөцийг бүрдүүлнэ. Санхүүгийн нөөцийн зөв хуваарилалтын явцад өрх, гэр бүлийн орлого бий болно. Санхүүгийн хуваарилалтын үүрэг хэрэгжих явцад түүний хяналтын үүрэг илэрнэ. Хяналтын үүрэг нь Төрийн хяналтын байгууллагаар дамжуулан санхүүгийн бие даасан арга хэрэгслүүдийн хууль эрх зүйн дагуу үнэн зөв, цаг хугацаандаа хэрэгжиж байгааг шалган тогтооно.


Нийгмийн нөхөн үйлдвэрлэлд шинээр

³ Дадашев, А. З. (2015), Финансы, о финансовых системах, Финансы, журнал №11, стр. 44

⁴ Болдбаатар, Д. (2005), Санхүү-миний ажил, амьдрал, 1-р дэвтэр, 257-р нүүр

⁵ Голикова, Е. И. (2010), Рыночная экономика, требует реальной модернизаций амортизационной политики, Финансы, Журнал №9, стр. 32

Зураг 1. Нийгмийн бүтээгдэхүүний бүтэц



бий болсон өртгийн хэдэн хувийг улсын төвлөрсөн санд хэдэн хувийг бизнес эрхлэгчид, өрхийн аж ахуйд тус тус оногдохыг санхүүгийн хуваарилалтын үүргийн тусламжтай хэрэгжүүлнэ.

Олон улсад шинээр бий болсон өртгийн хэдэн хувийг Төр өөрийн мэдэлд үлдээх талаар тогтсон нэг журам, хувь хэмжээ алга байна. Улс орон бүр санхүү төсвийн

бодлогоор дамжуулан шинээр бий болсон өртгийн харьцааг (хуваарилалтын) өөр өөрөөр тогтоож байна.

Шинээр бий болсон өртгийн харьцааг тодорхойлоход элэгдэл хорогдлын шимтгэл⁶, түүний хувь хэмжээ шууд нөлөөлнө. Энэ хувь хэмжээг аажим нэмэгдүүлснээр татвар оногдох ашиг орлого буурч, бизнесийн байгууллагын

⁶ Иванова, А. Н. (2017). Амортизационная политика как экономический рычаг для экономического роста, Финансы, журнал №3, стр. 24

санхүүгийн нөөц нэмэгдэх боломж бүрдэнэ. Төрөөс элэгдэл хорогдлын шимтгэлийг шинжлэх ухааны дэвшил, хөгжилтэй уялдуулан хувь хэмжээг өөрчлөх, хөрөнгө оруулалтыг оновчтой хэрэгжүүлэхэд анхаарах нь чухал болж байна.

Төрөөс үнийн өсөлтийг хязгаарлах нэгдсэн хяналт тавихын хамт хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг жил бүр шинэчилж тогтоох үүрэгтэй. Үнийн хэт өсөлтөөс болж ажиллагсдын нэрлэсэн болон бодит цалингийн хооронд хэт их зөрүү гарч өрхийн орлого буурахаас сэргийлэх шаардлагатай. Энэ тал дээр Төрийн хяналт, зохицуулалт суларч өрх гэр бүлийн орлого буурч, ядуурал нэмэгдэж байна.

Үйлдвэрийн газрын ашиг орлого тогтвортой байх, өрхийн орлого нэмэгдэх нь улсын (Төрийн) санхүүгийн тогтвортой байдал хангах үндэс юм. Бизнес эрхлэгч байгууллагын санхүүг бүрдүүлэгч хэрэгсэл нь ашиг, орлого, элэгдэл хорогдлын шимтгэл бол өрхийн санхүүгийн үндсэн элемент нь цалин, хөлс, нийгмийн

даатгалаас орох шилжүүлгийн орлого болно. Төр эдгээр субъектүүдийн санхүү, санхүүгийн харилцааны тогтвортой байдлыг хангах үүднээс хууль эрх зүйн үндсийг тодорхойлж эдийн засаг, санхүүгийн зөв шударга хуваарилалтын харилцааны суурийг бүрдүүлж өгөх ёстой. Хууль бус, хуйвалдааны, дарангуйллын эрүүл бус харилцааг гаргуулахгүй байх, илэрсэн нөхцөлд хуулийн дагуу хатуу арга хэмжээг авдаг журмыг мөрдүүлэхэд Төрийн үүрэг оролцоо маш чухал болж байна.

Улс, орон бүр санхүүгийн бодлого тодорхойлоход санхүүгийн системийн бүрэлдэхүүн хэсгүүдийн хөгжил, бие даасан байдлыг хангахад онцгой анхаарах болов. Улсын санхүүгийн системийн бүрэлдэхүүн хэсэг нь дараах байдлаар тодорхойлогдоно (Зураг 2).

Санхүүгийн системийг бүрдүүлэгч бүрэлдэхүүн хэсэг нь нийгмийн бүтээгдэхүүн ба ажиллах хүчний нөхөн үйлдвэрлэлд нягт холбоотойгоор бие даасан байдлаа хадгалан хөгжиж, бэхжиж

Зураг 2. Санхүүгийн системийн бүрэлдэхүүн



байдаг. Эдийн засгийн уналт, хямралын нөхцөлд санхүүгийн системийг бүрдүүлэгч хэсэгт дараах өөрчлөлт гарч байна. Үүнд:

- Улсын болон бусад сангуудад орох орлого буурна.
- Улсын төсвийн алдагдал өснө.
- Ажилгүйдэл нэмэгдэнэ.
- Өрхийн мөнгөн орлого буурна.
- Ашиг, орлого буурна.
- Алдагдалтай ажиллах байгууллагын тоо өснө.

Төрөөс⁷ эдийн засгийн хямралын үед санхүүгийн системийн хөгжилд гарч буй сөрөг үр дагаврыг хөгжлийн цаашдын чиг хандлага өөрчлөлттэй уялдуулан зайлшгүй сайжруулах, засах оновчтой арга хэмжээг хэрэгжүүлэх зорилт тулгарч байна.

Төрийн оролцоотойгоор эдийн засагт үүссэн хямрал, санхүүгийн хууль бус байдлыг засахын тулд дараах арга хэмжээнүүдийг үе шаттайгаар авч явуулах шаардлага үүсч байна. Үүнд:

Нэгдүгээрт: Орлогын эх үүсвэр хуваарилалтанд өөрчлөлт оруулах.

- Бизнесийн үйл ажиллагааны төрөл чиглэлийг харгалзан ашиг орлогын хэмжээнээс хамааруулан татварыг⁸ өсгөн нэмэгдүүлэх татвар оногдуулан олон улсын зарчимд нийцүүлэх чиглэлээр хувь хэмжээнд өөрчлөлт оруулах;
- Газрын доорх бүх төрлийн ашигт малтмалыг олзворлож, экспортод гаргаж буй баялаг, дотоодын бизнес эрхлэгчдийн санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж төрийн оролцооны хувийг 51 хувьд хүргэх;

- Газрын доорх баялагаас бусад бүх төрлийн орлого, баялагийн ашиглалтанд тавих хяналтыг сайжруулж олзворлож, ашиглаж буй бараа, бүтээгдэхүүнд төлбөр, хураамж ноогдуулах журам мөрдөх;
- Төр ба хувийн хэвшлийн хувьцааны ноогдол ашиг эзэмшигч субъектээс татвар оногдуулах журмыг мөрдөж эхлэх.

Хоёрдугаарт: Улсын төвлөрсөн сан бусад төсвийн зарлагын бүтцэд өөрчлөлт оруулах.

- Салбарын яам, агентлагийн ажлын уялдаа, холбоог нягтруулж орон тоо бүтцийн өөрчлөлт хийх, зардал хэмнэх;
- Төсвийн урсгал зардалд судалгаа хийж зардлын нэр төрлөөр нь хэт үрэлгэн их хувийн жин эзэлж буй цалингаас бусад зардлаас хэмнэлт хийх арга хэмжээ авах;
- Улсын төсвөөс үр дүн багатай валютын болон ханшийн өөрчлөлтөөс болон нөхөн санхүүжилт хийж буй одоогийн нөхцлийг өөрчлөх шаардлагатай.

Гуравдугаарт: Бизнесийн болон санхүүгийн таатай орчин бүрдүүлэх.

- Олон улсын, дэлхийн жишигт нийцсэн зээл, хадгаламжийн хүү тогтоох, зээл, хадгаламжийн хугацааг жилээр тооцох журамд шилжих;
- Засгийн газраас бүтээгдэхүүн, үйлчилгээний суурь үнийг бүрдүүлэгч тээврийн болон холбооны үнэ тарифийг бууруулах монополь компаниудын үндэслэлгүй олсон орлого, ашигт хяналт тавих;
- Суурь үнэд тооцогддог цахилгаан дулаан, шатахууны үнэ тарифыг ээлж дараатай бууруулах арга хэмжээг

⁷ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, 2010, нүүр хуудас 18-28

⁸ Гордеева, О. В. (2010). Налоговое регулирование и экономная система, Финансы, журнал №9, стр. 17

- хэрэгжүүлэх;
- Төрийн болон үйлчилгээний албан тушаалтны цалин хөлсийг үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлэх.

Дөрөвдүгээрт: Санхүү болон хөрөнгийн зах зээлийн хөгжлийг хангах.

Санхүү ба хөрөнгийн зах зээл нь хөрөнгө оруулагч, зээлдүүлэгч, зээл хүсэгчийн

хооронд үүссэн мөнгөн хөрөнгийн хэрэгцээг хангахтай холбогдсон чөлөөт мөнгөн хөрөнгийн (капиталын) дахин хуваарилалтын хамгийн том зах зээл гэж хэлж болно. Санхүү, хөрөнгийн зах зээл нь санхүүгийн системд бие даасан байдлаар оролцохгүй ч түүний бүрэлдэхүүн хэсгүүдийн уялдааг хангах, хөгжилд чухал үүрэгтэй оролцож байдаг.

Хүснэгт 1. Санхүүгийн зах зээлийн оролцогчид ба хэрэгслүүд

Санхүү, хөрөнгийн зах зээлийн субъектүүд (зохицуулагч, оролцогчид)	Зах зээл дээрх бүтээгдэхүүн (арга, хэрэгсэл)
<ul style="list-style-type: none"> - Засгийн газар - Бизнес эрхлэгчид - Зээлийн байгууллага - Даатгалын байгууллага - Тэтгэврийн болон бусад хөрөнгө оруулалтын сан - Татварын байгууллага - Бусад оролцогчид 	<ul style="list-style-type: none"> - Зээл - Хадгаламж - Үнэт цаас - Бонд - Ноогдол ашиг - Хүү - Хөрвөх хэрэгсэл - Бусад хэрэгслүүд

Зах зээл дээрх шударга өрсөлдөөн бий болгох, түүний хөгжлийг хангах зорилгоор авч явуулах арга хэмжээ:

- Засгийн газрын болон бусад олон улсын байгууллагын үнэт цаасны арилжаанд банкны хөрөнгө оруулах эрхийг хууль эрх зүйн хүрээнд хязгаарлах замаар олон улсын жишигт нийцүүлэх;
- Засгийн газрын болон хөрвөгч баталгаат үнэт цаасанд өрх, иргэдийн оролцоог бий болгох эрх зүйн орчин бүрдүүлэх;
- Оросын Холбооны Улс⁹ болон бусад орны туршлагаар иргэдэд зориулсан Засгийн газрын удаан хугацааны зээллэг гаргах ажлыг яаралтай эхлүүлэх;
- Зах зээл дээрээс санхүүгийн

бүтээгдэхүүн худалдан авах ажиллагааг техник, зохион байгуулалтыг улам сайжруулах, иргэдийн оролцоог амар хялбар, ил тод нээлттэй болгох, бусад орны туршлагыг хэрэгжүүлэх;

- Татвар, мөнгө санхүүгийн хөгжил¹⁰ нь дэлхийн улс орнуудын түвшинд үйлдвэр, бизнес эрхлэгчид болон хувь хүн, өрхийн санхүү бие даан амжилттай хөгжих нөхцөл боломжийг бий болгосон юм.

Улсын санхүүгийн системийг цаашид амжилттай хөгжүүлэх нь бизнес болон өрхийн санхүүгийн бие даасан байдлыг хангах, тэдний бизнесийн эрүүл орчин бүрдүүлэхээс шууд хамааралтай болох нь дэлхийн улс орнуудын туршлагаар улам бүр батлагдаж байна.

⁹ Черкасов, В. Е. (2010). Проблема о финансовых науках, Финансы, журнал №6, стр. 27

¹⁰ Баргулин, С. В. (2004). Сущность финансов: новые реалии, Финансы и кредит, журнал №5, стр. 7

Ашигласан материал

1. Баргулин, С. В. (2004). Сущность финансов: новые реалии, *Финансы и кредит*, журнал №5
2. Голикова, Е. И. (2010). Рыночная экономика, требует реальной модернизаций амортизационной политики, *Финансы*, журнал №9
3. Гордеева, О. В. (2010). Налоговое регулирование и экономная система, *Финансы*, журнал №9
4. Дадашев, А. З. (2015). Финансы, о финансовых системах, *Финансы*, журнал №11
5. Иванова, А. Н. (2017). Амортизационная политика как экономический рычаг для экономического роста, *Финансы*, журнал №3
6. Черкасов, В. Е. (2010). Проблема о финансовых науках, *Финансы*, журнал №6
7. Болдбаатар, Д. (2005). Санхүү-миний ажил, амьдрал, 1-р дэвтэр
8. Төсвийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/, Төрийн мэдээлэл эмхтгэл, 2012, №3
9. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхтгэл, 2010, №30
10. <http://www.mof.gov.mn>
11. <http://www.parliament.mn>
12. <http://www.legalinfo.mn>

